



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 1 сарын 2 өдөр

Дугаар А/1

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалт, 8.4 дэх хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, Засгийн газрын 2022 оны 470 дугаар тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 2.1, Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны А/167 дугаар тушаалаар батлагдсан “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын 2.1, 3.1-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас тусгах саналыг хууль тогтоомжийн хүрээнд судлан боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:


- |         |                |  |
|---------|----------------|--|
| Ахлагч: | Н.Ганболд      | - Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга;   |
| Гишүүд: | Д.Дэлгэрмаа    | - Хууль, эрх зүйн хэлтсийн дарга;  |
|         | Ц.Баяр-Эрдэнэ  | - Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга;   |
|         | Д.Нарангэрэл   | - Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга;  |
|         | Ц.Түвшинзаяа   | - Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн дарга;   |
|         | В.Дарханбаатар | - Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн Удирдлага, төлөөллийн албаны ахлах мэргэжилтэн (Албаны дарга); |
|         | Д.Батболд      | - Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн;  |
|         | Д.Цэрэнлхам    | - Захиргаа, удирдлагын хэлтсийн Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын мэргэжилтэн;                           |
|         | М.Баярмаа      | - Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн;  |
|         | Д.Отгонтуяа    | - Ерөнхий нягтлан бодогч;  |

132013813

Нарийн Х.Энхчимэг - Захиргаа, удирдлагын хэлтсийн Тогтоол  
бичиг: шийдвэрийн биелэлт хариуцсан ахлах  
мэргэжилтэн.

2.Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас тусгах саналыг хууль тогтоомжийн дагуу нөхцөл байдлын дүн шинжилгээнд тулгуурлан боловсруулж, 2024 оны 1 дүгээр сарын 05-ны өдрийн дотор танилцуулах, холбогдох байгууллагад хуулийн хугацаанд хүргүүлэх арга хэмжээ авч ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Н.Ганболдод үүрэг болгосугай.

3.Төлөвлөгөөг боловсруулахад шаардлагатай судалгаа, мэдээллээр хангаж, санал, үр дүнг төлөвлөхөд хариуцсан чиг үүргийн хүрээнд ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх, уялдаа холбоог хангаж ажиллахыг хэлтэс, албаны дарга нарт даалгасугай.

ДАРГА  Б.ЦЭНГЭЛ